

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

**/АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

Захиалагч: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам

Гүйцэтгэгч: “Ажиглалт” ХХК

**УЛААНБААТАР ХОТ
2025 он**

АГУУЛГА

Танилцуулга

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал	4
1.1.Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ	4-7
1.2. Ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхойлох	7-8
1.3. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл үүсдэг вэ, ямар зүйл заалт хэрэгжихгүй байна вэ, эдгээр нь ямар шалтгаан, хүчин зүйлтэй холбоотой байгааг тодорхойлон дүгнэлт өгөх	8-9
1.4.Хуулийн зохицуулалтаар ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бусад этгээдийг тодорхойлох	10
Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томёолсон байдал	10-12
Гурав. Асуудлыг зохицуулах хувилбаруудын харьцуулсан судалгаа ..	12-15
Дөрөв. Хуулийн зохицуулалтын хувилбар, түүний үр нөлөө	15-16
4.1.Хуулийн зохицуулалтын хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал	16
4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	16-17
4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	17-19
4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	19-21
4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	21-23
Тав. Хуулийн зохицуулалтын хувилбарыг харьцуулсан байдал	23
5.1.Олон улсын ашигт малтмалын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа	
5.1.1. ОХУ-ын уул уурхайн салбар дахь туршлага	24-27
5.1.2. Индонез улсын уул уурхайн салбар дахь туршлага	27-28
5.1.3. Бразил улсын уул уурхайн салбар дахь туршлага	28-30
5.1.4. Энэтхэг улсын уул уурхайн салбар дахь туршлага.....	30-31
5.1.5.Чили улсын уул уурхайн салбар дахь туршлага.....	31-34
Зургаа. Зөвлөмж	35

ЗУРАГ

Зураг 1. Урьдчилан танадан судлах ажлын үе шат	4
Зураг 2. Асуудлыг зохицуулах хувилбарууд	12

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал.....	16
Хүснэгт 2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал	17
Хүснэгт 3.. Ниймгэмд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал	19
Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал	20
Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт	24

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлд зааснаар газрын хэвлийн баялаг нь гагцхүү ард түмний мэдэлд байна. Харин уг баялгийг ард түмний нэрийн өмнөөс эрхлэн удирдах, хамгаалах эрхийг төр хэрэгжүүлэх бөгөөд энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ а) урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлах, б) өнөө болон ирээдүй үеийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, в) газрын хэвлийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх замаар тэгш, шударга хүртээх, г) байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг хангах, д) стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх зэрэг хэрэгцээ шаардлагад нийцсэн, уг асуудлаарх эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай байгаа билээ. Энэхүү шаардлагыг урьдчилан танадан судлах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан танадан судлах аргачлал”-ыг удирдлага болгон уг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан танадан судлах ажлыг аргачлалд заасны дагуу дараах үе шаттай гүйцэтгэж, тайланг боловсруулав.

Зураг 1.



НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ:

Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилтын хүрээнд тус салбарын оролцогчдын эрх ашгийг хангах, улсын байгаль орчин, хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, уялдаа холбоог нарийвчлан зохицуулах, нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлага болон бусад хуультай

нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилган шаардлага зайлшгүй тулгараад байна.

Түүнчлэн *Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан* Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.1-т “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ”, 3.4.2.8-т “Уул уурхайн нөхөн сэргээлтийн чанар, хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагыг чангатгана”, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.1.1-т “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ” гэж тус тус заасан.

1.Үндсэн хууль ба геологи, уул уурхайн харилцаа. Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль 1992 онд батлагдаж иргэдийн байгалийн баялагийг ашиглах, үр өгөөж хүртэх эрхийг баталгаажуулсан. Энэхүү Үндсэн хуулиар дараа дараагийн бусад шинэ хуулиудыг бий болгох, хэрэгжих үндсийг бүрдүүлж өгсөн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заасан.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрөөс эдийн засгийг зохицуулах, байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байх, иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаажуулахад уул уурхайн салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” хэмээн заасан нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, үндэсний үзэл санаа, иргэдийн эрх ашиг, газраас олох эдийн засгийн үр ашгийг нийт ард иргэдэд жигд хүргэх эрх зүйн үндэс бүрдүүлэх шаардлага үүссэн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялагийг ашиглах, үр өгөөжийг нь ард түмэнд хүртээхийг хүлээн зөвшөөрч, ард түмний эрхийг хамгаалах, эдийн засгийн олон хэвшилд тулгуурласан зах зээлийн харилцааг бэхжүүлэх, эдийн засагт төрийн оролцоог багасгах, байгаль, түүний баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх харилцааны үндсийг мөн тодорхойлсон. Энэ хүрээнд ашигт малтмалын суурь харилцааг зохицуулж буй ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байсаар байна.

2.Ашигт малтмалын харилцааны эрх зүйн орчин. Ашигт малтмалын тухай хууль нь Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг, салбарын оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийн зохицуулсан, бусад хуультай нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага үүсээд байна.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд 11 бүлэг 66 зүйлтэйгээр баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 11 бүлэг 59 зүйлийн хэсэг, заалтууд ямар нэгэн байдлаар хөндөгдсөн байна. Ингэснээр хуулийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч хуулийн оновчтой зохицуулалт дутагдаж, улс орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийг сааруулах, өрсөлдөх чадварыг алдагдуулах, хөрөнгө оруулалтыг бууруулах нөхцөл байдлыг үүсгээд байна.

Хууль хэрэгжсэн хугацаанд Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилт нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг бий болгосон байна.

3.Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо. Манай улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж шинэ Үндсэн хууль батлагдсанаар нутгийн удирдлагын тогтолцоог өөрчлөн байгуулах эрх зүйн орчин бүрдсэн юм.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаарх Үндсэн хуулийн үзэл баримтлал нь манай улсын төвлөрсөн удирдлагаас ангижрах гол нөхцөлийг бүрдүүлж өгснөөр орон нутгийн удирдлагын тогтолцоо шинэчлэгдэж ардчилсан нийгэмд иргэн бүр өөрийн амьдарч буй орон нутгийнхаа асуудлыг шийдвэрлэхэд шууд оролцох, мөн төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийн эрх барих, шийдвэр гаргах түвшинд шударга, эрх тэгш, чөлөөтэй оролцох эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллага болох иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг Үндсэн хуулийн байгууллага болгон баталгаажуулж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар бүрэн эрхийг нь тусгайлан баталсан. Нутгийн өөрөө удирдах байгууллага буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн амьдралд ихээхэн нөлөөтэй асуудлуудаар хамтын шийдвэр гаргах, иргэдийн дуу хоолойг орон

нутгийн бодлого, төсөв, төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлд тусгах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргүүдийг хуулиар хүлээсэн бие даасан байгууллага болж бүрэн эрхээ хэрэгжүүлээд 20 гаруй жил өнгөрсөн байна. Энэ утгаараа байгалийн баялагийг ашиглах үйл ажиллагаанд нутгийн удирдлагын бүрэн эрх хангалттай хэмжээнд хуульчлагдсан байна.

Гэтэл одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын тухай хуульд уул уурхай, эрдэс баялагийн харилцааны асуудал орон нутгийн удирдлага /нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага/-ын оролцоотой байхаас гадна мэргэжлийн байх, нэгдсэн тогтолцоотой байх, хариуцлага хяналтын систем өндөр байхыг шаардаж байна. Иймд орон нутгийн удирдлага, нутгийн захиргааны байгууллагын хариуцлага, хяналт, олон нийтийн оролцоог хуульд тусгах шаардлагатай болж байна.

4.Ашигт малтмалын харилцааны нэгдсэн бодлого, зохицуулалт. Ашигт малтмалын тухай хууль нь уурхайн амьдралын мөчлөгтэй холбоотой харилцаанд талуудын оролцоог иж бүрнээр нь зохицуулаагүй, зарим зохицуулалт нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай төдийлэн уялдахгүй байна. Ашигт малтмалын тухай хууль нь “тусгай зөвшөөрөл”-тэй холбоотой харилцааг голчлон зохицуулах, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, олборлолт, баяжуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нөхөн сэргээлт, “хаалт”-тай холбоотой харилцааг нарийвчлан тодорхойлох хэрэгтэй байна.

Уул уурхайн салбар дахь авилгын судалгаагаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос ашиглалт хүртэлх үе шат нь эрсдэл өндөртөйд тооцогддог ба авилгын эрсдэлийн үндсэн шалтгаанд уул уурхайн салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүд нь хэт ерөнхий зохицуулалттай буюу тухайлсан зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй, аливаа зохицуулалтад тавигдах шаардлага тодорхойгүй гэж тодорхойлжээ. Монгол Улс байгалийн баялгийн засаглалын индексээр “Засаглал хангалтгүй” гэсэн ангилалд багтаж байгаа бөгөөд энэ нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого, зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн Ашигт малтмалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акттай нийцсэн байх ба уул уурхай, эрдэс баялагийн боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, баримтлах үндсэн зарчимд тулгуурласан бодлого, зохицуулалтыг шаардаж байна.

Иймд уул уурхай, эрдэс баялагийн салбарын бүртгэл, ашиглалт, хамгаалалтад хяналт тавьдаг байх, аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, эзэнжүүлэх зохицуулалтыг нэмэх, ашигт малтмалын ордыг ашиглах ТЭЗҮ тавигдах шаардлага, эрх үүргийг тодорхойлох нь зүйтэй.

Мөн АМНАТ-ийн түвшин ямар байх, татвар ноогдох суурийг яаж тооцох, АМНАТ ямар хэлбэртэй байх зэрэг нь тухайн улсын хуулиар зохицуулагдаж байдаг ч их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, урт хугацааны төсөл хэрэгжүүлэх аж ахуйн

нэгжүүдийн хувьд татварын орчин тогтвортой байх нь чухал байдаг тул татварын орчинг гадаадын хөрөнгө оруулагчид болон дотоод аж ахуйн нэгжүүдэд тодорхой, ил тод, ойлгомжтой байлгах нэгдсэн бодлого баримтлах нь зүйтэй.

1.2.Ашигт малтмалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхойлох:

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд баримтлах хуулийн үндсэн зарчим, агуулгыг томъёолсон байна. Энэ хуулийн зорилтыг “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон бөгөөд шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 16 жил хэрэгжиж, энэ хугацаанд өөрийнхөө зорилгыг биелүүлсэн гэж үзэж байна. Гэвч энэ хугацаанд зарчмын өөрчлөлт ороогүй бөгөөд өнөөгийн хурдтай хөгжиж байгаа эдийн засаг, нийгмийн олон талт харилцаатай нийцүүлэх шаардлагыг үүсгэсэн байна. Тухайлбал тус хуулинд “Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх”, “Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох”, “Уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний төрөл, төлөвлөлт”, “Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа” зэрэг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн олон асуудлыг тусгаж, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Тус хуулийн зорилтыг “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон нь даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын нэг болсон газар, түүн дээрх нөөц баялгийг үр ашигтай ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх харилцааг зохицуулахаар тусгасан байна. Түүнчлэн, дэлхий нийтээр цахимжиж байгаатай холбоотойгоор баялагийн мэдээллийн систем, мэдээллийн сан, орон зайн өгөгдөл мэдээлэл зэрэг ойлголтууд шинэ түвшинд яригдах болсон бөгөөд эдгээр асуудлын үндсийг Ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлж өгөх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

1.3.Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл үүсдэг вэ, ямар зүйл заалт хэрэгжихгүй байна вэ, эдгээр нь ямар шалтгаан, хүчин зүйлтэй холбоотой байгааг тодорхойлон дүгнэлт өгөх:

Монгол Улс нь дэлхийд дээгүүрт орох ашигт малтмалын баялаг нөөцтэй бөгөөд нүүрс, зэс, молибден, алт, хайлуур жонш, газрын тос зэрэг 80 гаруй нэр төрлийн ашигт малтмалын нөөцтэй билээ. Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг шударга, нээлттэй ил тод зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох боломжийг хангах, экспортыг нэгдсэн бодлогоор зохицуулах замаар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, улс орны эдийн засгийн өсөлтөд энэ салбарын оруулах хувь нэмрийг улам өргөжүүлэх шаардлага тулгараад байна.

Сүүлийн жилүүдэд уул уурхай, олборлох салбар өндөр хурдацтай хөгжиж 2005 оноос хойш дотоодын нийт бүтээгдэхүүнд энэ салбарын эзлэх хувийн жин 20 гаруй хувьд хүрсэн.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71 хувь, экспортын 94 хувийг бүрдүүлж

байгаагийн хувьд энэ салбар нь манай улсын эдийн засгийн тулгуур багана болж байна. Энэ ч агуулгаар уул уурхайн салбараас хүртэх орлогыг ил тод, хамгийн боломжит үнээр төвлөрүүлэх нь чухал юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний дотоод, гадаад зах зээлийн арилжаанд дараах хүндрэлүүд тулгарч байна. Үүнд:

- Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн бодит үнэ, худалдааны нөхцөл, бүтээгдэхүүний чанарын талаарх мэдээлэл нээлттэй ил тод бус байдгаас үр ашигтай гэрээ хэлцэл хийх боломж муу, зардал өндөр;
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг борлуулах зохион байгуулалттай зах зээл бий болоогүй улмаас бүтээгдэхүүний үнэ ханш дэлхийн зах зээлийн үнээс үлэмж доогуур;
- Гэрээний үндсэн дээр арилжаалагдах уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээ нь гэрээний үнээр тогтоогдож, хууль тогтоомжийн дагуу албан татвар, төлбөр, хураамжийг ногдож байна. Гэвч гэрээгээр тохирсон үнэ нь зах зээлийн ханшнаас үлэмж зөрүүтэй байдгаас уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас олох орлогыг ихээхэн бууруулж байгаа;
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дийлэнх нь хөрөнгө оруулалт байхгүй гэсэн шалтгаанаар үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа;
- Хариуцлагагүй уул уурхайн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн бухимдлыг тэрүүлэх болсон ба ард иргэдийн эрх ашиг, байгаль орчноо хамгаалах иргэний нийгмийн байгууллагуудын уул уурхайг эсэргүүцэх үйлдлүүд удаа дараа гарч байгаа;
- Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн эрсдэлийг хамгаалах ирээдүйн фьючерсын гэрээг хийдэггүй, зах зээлийн өндөр үнээр дараа жилүүдэд үйлдвэрлэх бүтээгдэхүүнээ өндөр үнэтэй байхад нь борлуулж нэмэлт орлого олох боломжоо алдсаар байна.

Манай улсад Ашигт малтмалын тухай хуулийн агуулга нь нөхөн сэргээгдэхгүй баялгийг нийт улс орон, хүн ардын хэтийн сайн сайхны төлөө урт хугацааны бодлого зохицуулалттайгаар ашиглах зарчмыг дэмжихэд чиглэх учиртай.

Иймд төрийн нийтийн өмч болох газрын хэвлийн баялгийг зохисгүй ашиглалтаас хамгаалах, ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нарийвчлах, салбарын үйл ажиллагаанаас байгаль орчин, олон нийтийн эрх ашигт үзүүлэх нөлөөллийн асуудлыг тэргүүн ээлжинд авч үзэн зохицуулах, салбарт оролцогчдын ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах байдлаар хариуцлагатай уул уурхайг дэмжих чиглэлд хуулийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

Уул уурхайн салбараас хүртэх орлогыг ил тод, хамгийн боломжит үнээр төвлөрүүлэхэд олон хүндрэл бэрхшээл үүсдэг байна.

Тухайлбал: Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байгууллагуудад мэдээлэл тэгш байдлаар хүрдэггүйгээс зах зээлийн өрсөлдөөний зарчмаар эрдэс бүтээгдэхүүний худалдаа хийгдэж чадахгүй байгаа нь манай орны эрдэс баялгийн үнэлэмжийг ихээхэн бууруулж байна.

Улс бүр өөрийн үндэсний аюулгүй байдалд болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд шууд хамаарал бүхий ашигт малтмалыг “Чухал” бүлэгт хамааруулан зарлаж тухайн төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэх чиглэлд тусгайлан бодлого гарган хэрэгжүүлж байна.

Иймд Монгол Улсын хувьд чухалд тооцогдох ашигт малтмалын төрлүүдийг тодорхойлж, түүнтэй холбоотой бодлогыг улсын хөгжлийн бодлогуудад тусгайлан тусгаж хэрэгжүүлэх, энгийн ашигт малтмалаас онцлог зохицуулалт, үйл ажиллагааны горимтой байх нөхцөлүүдийг хуулиар зохицуулах нь зүйтэй байна.

1.4.Хуулийн зохицуулалтаар ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бусад этгээдийг тодорхойлох:

Орон нутагт уул уурхайн төсөл хэрэгжүүлэх, ААН үйл ажиллагаа явуулахад тулгардаг нийтлэг бэрхшээлтэй харилцаа нь тухайн аймаг, сум, дүүргийн Засаг даргын эрх хэмжээнээс хамаарч байдаг. Тэгвэл хуулийн шинэчилсэн найруулгаар Засаг даргын эрх хэмжээг танилцуулах, тайлагнах, мэдээлэх, зохион байгуулах гэдгээр тодорхойлжээ.

Энд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эрлийн ажлын үед орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах шаардлагагүй гэж үзжээ. Харин ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах бол орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулна гэж тусгажээ. Мөн орон нутагтай хамтран ажиллах гэрээнд тусгагдаагүй хандив, тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нэхэж шаардахыг хориглож байна. Орон нутагтай тухайн ААН хамтран ажиллах гэрээ байгуулах журмыг Засгийн газар баталж байхаар тусгажээ.

Стратегийн ач холбогдол бүхий ордын ойлголтыг анх 2006 онд Ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлж, Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор нийт 15 ордыг анх стратегийн ач холбогдол бүхий ордод хамааруулсан нь 2015 онд нэгээр нэмэгдэж, 16 орд болсон бөгөөд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхээр нийт 39 ордын асуудлыг Засгийн газарт даалгаснаас хойш эдүгээ 18 жил өнгөрсөн байна.

Тус тогтоол батлагдсанаас хойш даруй 12 жилийн дараа Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан. Гэвч уг заалтын хэрэгжилтийг хэрхэн хангах, ямар хувилбар нь илүү бодитой, илүү оновчтой байх талаар нэгдсэн ойлголт бий болгох шаардлага байсаар байна.

Стратегийн ач холбогдол бүхий ордуудын тухайд төрийн эзэмшлийн асуудлыг хүчээр тулган шийдэх бус, харин тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай харилцан зөвшилцөлд хүрэх замаар шийдвэрлэх хэлэлцээ нь зөвхөн төрийн эрх ашигт нийцэхээс гадна хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, харилцан итгэлцлийг бий болгоход анхаарах шаардлага үүссэн байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан танадан судлах аргачлал”-д зааснаар уг ажлын зорилт нь тодорхой асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, энэ асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоход оршино гэж тодорхойлсон.

Хуулийн зорилтыг хангахад хуулийн зохицуулалт чиглэгдэх ёстой. Одоогийн байдлаар Монголын уул уурхайн салбарт дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

1.Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль нь уурхайн амьдралын мөчлөгтэй холбоотой харилцааг иж бүрнээр нь зохицуулаагүй, зарим зохицуулалт нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай төдийлэн уялдаагүй;

2.Ашигт малтмалын тухай хууль нь “тусгай зөвшөөрөл”-тэй холбоотой харилцааг голчлон зохицуулахад чиглэгдсэн бөгөөд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, олборлолт, баяжуулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нөхөн сэргээлт, хаалттай холбоотой харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан;

3.Хуулийн зарим заалт нь хэт ерөнхий зохицуулалттай буюу тухайлсан зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй, аливаа зохицуулалтад тавигдах шаардлага тодорхойгүй;

4.Байгаль орчны хууль тогтоомж, Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хууль, бусад холбогдох журмаар уул уурхайн салбарт холбогдох асуудлыг тодорхой хүрээнд зохицуулж байгаа боловч тэдгээрийн өөр хоорондын уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалтгүй;

5.Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо ихтэй, улс төрийн нөлөөлөлд өртөмтгий зэрэг болно.

Дээрхээс дүгнэн үзэхэд Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулагдаагүй зарим асуудлуудыг тусган, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэхүү асуудлуудыг шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар томъёолж байна. Үүнд:

- Баяжуулах үйл ажиллагааг эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн үйл ажиллагаатай холбоотой тавигдах шаардлагыг тусгах, оролцогч талын эрх, үүргийг тодорхойлох, баяжуулах үйлдвэрийн хаягдын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавигдах шаардлагыг нарийвчлан тусгах;

- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох харилцааг зохицуулах;
- Стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт болон уг хуулийн зохицуулалттай холбоотой бусад асуудлыг Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хуулийн төсөлд тусгах;
- Ашигт малтмалын үйл ажиллагаатай холбоотой уурхайг хаасны дараа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх болон байгаль орчны нөхөн сэргээлт хийх ажлыг зохих ёсоор хийх санхүүгийн нөөцийг бүрэлдүүлэх, АМНАТ зэрэг асуудлыг тусган тодорхой болгох;
- Засгийн газар болон төрийн захиргааны байгууллагууд, олон нийтийн оролцоо зэргийг бусад хуулиар зохицуулсан заалттай давхардал, хийдэлгүйгээр зохицуулах нөхцлийг судалгаанд үндэслэн тусгах.

Уул уурхай, эрдэс баялагийн харилцаанд эрх зүйн зохицуулалт нь шууд утгаараа газар, газрын дорх баялагтай холбогдон үүсэх эрх зүйн хэм хэмжээний тухай ойлголт боловч өргөн агуулгаар нь авч үзвэл үндэсний аюулгүй байдал, байгаль орчин, хотжилт, уул уурхай, дэд бүтэц, татвар, өмч, амьжиргааны түвшин, үйлдвэржил, хөдөө аж ахуй гэх мэт олон асуудлуудын орон зайн хуваарилалт, түүний эрх зүйн зохицуулалтын асуудал юм. Энэ утгаараа газар, газрын дорх баялагтай холбоотой хууль эрх зүйн асуудал хэр зэрэг зөв оновчтой байхаас хамаарч тухайн улсын хөгжил дэвшил, бүтээн байгуулалт хамаардаг байна. Гэвч өнөөгийн Монгол Улсад нийгэм, эдийн засгийн олон талт харилцаанаас үүдсэн засаглалын болон эрх зүйн ялгаварт нөхцөл байдал уг харилцаанд үүссэн байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоох, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд зохицуулалтын дараахь хувилбаруудыг авч үзлээ. Үүнд:

- “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
- Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
- Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
- Төрөөс санхүүгийн интервенц хийх;
- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
- Захиргааны шийдвэр гаргах;

- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Зураг 2.



Хувилбар- 1. “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;

“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах зэрэг хувилбарууд нь тулгамдаад байгаа асуудлыг үр нөлөөтэй, бодитой шийдвэрлэх боломжгүй болохыг судлан тогтоов.

Хувилбар- 2. Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;

Тулгамдаж буй асуудлыг зөвхөн нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс гадна олон нийтийг хамруулсан сонсгол, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах, гарын авлага, мэдээллийн хуудас зэргийг ашиглан шийдвэрлэх боломжгүй байна.

Хувилбар- 3. Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;

Энэ хувилбар нь татвар, хураамжийн бодлого, эсхүл зөвшөөрөл, лиценз болон квот зэргээр тодорхой хязгаарлалтыг тогтоох зэргээр зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт юм. Энэхүү зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх замаар тулгамдаад байгаа асуудлыг бүрэн дүүрэн шийдвэрлэх боломжгүй юм.

Хувилбар- 4. Төрөөс санхүүгийн интервенц хийх;

Төрөөс шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг, татаас үзүүлэх аргаар зохицуулалт хийх нь асуудлыг шийдвэрлэх оновчтой хувилбар биш болно.

Хувилбар- 5. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19.1-д “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно” гэж заасан байна.

Хувилбар- 6. Захиргааны шийдвэр гаргах;

Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар захиргааны үйл ажиллагаа захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт гаргах хэлбэртэй байдаг ба хуульд өөрөөр заасан тохиолдолд захиргааны байгууллага тухайн хуульд заасны дагуу хэрэглэнэ.

Хувилбар- 7. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар:

Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд харьцуулан судалсан:

1. зорилгод хүрэх байдал;
2. зардал, үр өгөөжийн харьцаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр анх тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоосон. Ингэхдээ тухайн зохицуулалтын хувилбарыг өөр салбарт хэрэглэсэн адилтгах туршлага байгаа эсэхийг судалж, уг асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд болон салбарын мэргэжилтнүүдийн саналыг сонсож, өмнө хийсэн судалгааны материал ашиглах зэрэг ажиллагааг хийсэн.

“Зардал, үр өгөөжийн харьцаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсвөөс зардал гарах эсэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд захиргааны ачаалал, нэмэлт зардал үүсэх эсэхийг ерөнхий байдлаар тандан судалж хавсаргаад байна.

Хуулийн төсөл нь геологи, уул уурхайн салбарын тогтолцоо, стратегийн чухал ашигт малтмалын талаар, хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох, ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа, түүний зарчим, тусгай зөвшөөрлийн зохицуулалт, уурхай, үйлдвэрийн хаалт, нөхөн сэргээлт, бичил уурхайн үйл ажиллагаа болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, геологи, уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт, нутгийн захиргааны байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулсан дараах 8 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

1 дүгээр зүйлд баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх, хаягдлын аж ахуй, эргэлтийн усан хангамжид тавих шаардлагатай холбоотой зохицуулалтууд бүхий баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулах бүлгийг нэмэхээр хуулийн төсөлд тусгана. Мөн уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаа, түүний

төрөл, төлөвлөлттэй холбоотой зохицуулалтууд бүхий уурхай, үйлдвэрийн хаалтын харилцааг зохицуулах бүлгийг нэмэхээр хуулийн төсөлд тусгана.

2 дугаар зүйлд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь нэгж, хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг бүртгэх, хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх, стратегийн чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа, олон нийтийн оролцоотой холбоотой харилцааг зохицуулсан зүйлүүдийг нэмэхээр хуулийн төсөлд тусгана.

3 дугаар зүйлд ашигт малтмалын өмчлөл, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгаа болон эрдэм шинжилгээний ажил, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг, нутгийн захиргааны байгууллагатай харьцах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон мэдээ, тайлан гаргахтай холбоотой харилцааг зохицуулсан хэсгүүдийг нэмэхээр хуулийн төсөлд тусгана.

4 дүгээр зүйлд хуулийн нэр томъёоны тодорхойлолт, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага, Засгийн газрын бүрэн эрх, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мэдээ, тайлан гаргах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох үндэслэлтэй холбоотой харилцааг зохицуулсан заалтуудыг нэмэхээр хуулийн төсөлд тусгана.

5 дугаар зүйлд хуулийн нэр томъёоны тодорхойлолт, ашигт малтмалын ордын ангилал, Засгийн газрын бүрэн эрх, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбайг ялгах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргах, түүнийг бүртгэх журам, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, тусгай зөвшөөрлийн төлбөр, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг, нутгийн захиргааны байгууллагатай харьцах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мэдээ, тайлан гаргах, тусгай зөвшөөрөл дуусгавар болох үндэслэл, тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан зүйл, хэсэг, заалтуудыг өөрчлөн найруулахаар хуулийн төсөлд тусгана.

6 дугаар зүйлд Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтуудад тусгагдсан “ашигт малтмалын нөөц ашигласны” гэснийг “газрын хэвлийн баялаг ашигласны” гэж, мөн зарим зохицуулалтад тусгагдсан үгийг тус тус өөрчлөхөөр хуулийн төсөлд тусгана.

7 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээ, ашигт малтмалын өмчлөл, төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, мэдээ,

тайлан гаргахтай холбоотой харилцааг зохицуулсан зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцохоор хуулийн төсөлд тусгана.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАР ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудаас эрх зүйн зөв, тогтвортой орчинг бий болгох хуулийн төсөл боловсруулах замаар ашигт малтмалын баяжуулалтын үйл ажиллагаа, хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох, уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох, орон нутгийн уялдаа холбоо, иргэд, олон нийтийн оролцоо, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хамарсан эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бөгөөд хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хувилбарыг сонгосон болно.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу асуудлыг зохицуулах үндсэн хувилбар нь хуулийн төсөл боловсруулж, батлах асуудал болохыг тогтоосон бөгөөд энэхүү хуулийн зохицуулалтын хувилбарын хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа холбогдох аргачлалд дурдсан суурь ойлголтуудыг харьцуулан дүгнэлт хийв. Сонгосон хувилбарын үр нөлөөг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын 6.2-т заасан ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хавсралтаар харуулав.

4.1.Хуулийн зохицуулалтын хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал:

4.1.1.Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Хүснэгт 1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхахыг хориглосон эсвэл дэмжсэн заалт, зохицуулалт хуулийн төсөлд дурдаагүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	-
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын нийт иргэдэд тэгш, хүртээмжтэй байхаар зохицуулсан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-

1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Холбогдох хуульд тусгаж өгнө.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Нийцэж байна.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	-
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Энэ талын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	-
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн үзэл баримтлалаас зөрүүтэй, хүйсийн ялгаварт байдал үүсгэсэн зохицуулалт байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тэгш эрхийг хангах боломжтой.

4.1.2.Эдийн засагт үзүүлэх нөлөө

Хүснэгт 2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид аль нэгэнд нь давуу эрх олгоогүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	-

	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	-
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Монопол нөхцөл байдлыг үүсгэх зохицуулалт, заалт байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	АМНАТ-т өөрчлөлт орно.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	-
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	-
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхлэх гадаад, дотоодын аж ахуй нэгжүүдийн тоо нэмэгдэнэ.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой нэмэгдэл зардал гарна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Газрын харилцаа болон баялагийн сантай холбоотой зохицуулалтыг агуулсан.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Энэ талаар зохицуулсан заалт байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх,	Тийм	Үгүй	-

	дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	-
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Жижиг, дунд үйлдвэр, уул уурхайн баяжуулах салбарыг дэмжсэн зохицуулалт орсон.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт эерэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Өөрчлөлт гарахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Өөрчлөлт гарахгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эдийн засаг өснө. Ажил эрхлэлт нэмэгдэнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	-
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

4.1.3.Нийгэмд үзүүлэх нөлөө

Хүснэгт 3.. Нийгэмд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал,	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	-
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	-

хөдөлмөрийн зах зээл	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Иргэд, аж ахуйн нэгжийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зохицуулалтууд орсон.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	-
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	-
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Тэгш бус байдал үүсэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	-
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тус чиг үүргийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хариуцлага, хяналтыг улам бүр сайжруулах шаардлага тулгарна.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
5.Нийтийн эрүүл мэнд,	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-

аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэд, олон нийтийн оролцоотой уул уурхай, эрдэс баялагийн салбарын үйл ажиллагаанд хуулийг нэгмөр мөрдөж, түүх, соёл, баялагаа хамгаалах боломжтой.

4.1.4.Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
------------------	------------------	---------	---------

1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	-
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	-
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөл газар ашиглалтын хэлбэрүүдийг хориглох зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгана.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	-
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	-
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлаар дамжуулан хөрсний бохирдолд мониторинг хийх боломжийг бүрдүүлнэ.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	-
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Газрын зориулалтыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зөвшөөрөгдсөн ашиглалтын төрлөөр өөрчлөх боломжтой.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	-
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	-
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	-

ТАВ. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлт болон Ашигт малтмалын тухай хуульд оруулсан 2024 оны 4 дүгээр сарын 19-ний нэмэлт, өөрчлөлтийн аль алины тухайд уг хуулийн өөрчлөлтүүдийг буцаан хэрэглэх тухай хуульчилсан зүйл байхгүй байх тул буцаан үйлчлэх ёсгүй гэж үзэж байна. Гэтэл, стратегийн ач холбогдол бүхий ордуудын тухайд төрийн эзэмшлийн асуудлыг өнгөрсөн хугацаанд шийдвэрлэсэн ордуудад Ашигт малтмалын тухай хуулийн 2024 оны өөрчлөлтийн дагуу дахин төрийн эзэмшил тогтоох асуудал хөндөж байгаа нь оновчтой хувилбар биш юм. Хууль өөрчлөгдөх бүрд төр дахин дахин эзэмшил тогтоодог байх боломжгүй. Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлд 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөд бусдын хувийн өмчийг үнэ төлбөргүйгээр төрийн мэдэлд авах агуулга огт байгаагүй. Хэрэв хөрөнгө оруулалт хийсний үндсэн дээр авдаг хувьцааг төр үнэ төлбөргүйгээр авах тохиолдолд энэ нь Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан өмчлөх эрхийн баталгааг үгүй хийх юм. Ингэснээр тус хэсэгт заасан хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрх зөрчигдөж, хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглосонтой зөрчил үүснэ. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт “3.2.2.1.Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.” гэж тусгасан нь хэлэлцээр хуулийн хүрээнд амжилттай явагдахгүй бол уг заалт нь хий хоосон амлалт болох эрсдэлтэй.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогы баримт бичигт “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна” гэж, “Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.” Гэж тус тус заасан.

5.1. Олон улсын ашигт малтмалын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа

Аливаа орны эдийн засаг урт хугацаанд, тогтвортой хөгжихөд эдийн засгийн салбаруудын төрөлжилт, хоорондын уялдаа холбоо чухал нөлөөтэй байдгаас гадна улс орны эдийн засгийн онцлогоос хамаарсан тэргүүлэх салбаруудын бусад салбартаа үзүүлэх дам нөлөө чухлаар тавигддаг билээ. Учир нь дотоодын нийт бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт, төсвийн орлого, ажил эрхлэлт зэрэг нийгэм, эдийн засгийн голлох үзүүлэлтэд эдийн засгийн тэргүүлэх салбарын үйлдвэрлэл, түүний хэлбэлзэл голлох нөлөөг үзүүлж байдаг. Монгол Улсын хувьд тэргүүлэх салбар болоод буй уул уурхайн салбарын томоохон төслүүдэд орж ирсэн шууд хөрөнгө оруулалтын их хэмжээний урсгалын бусад салбаруудад үзүүлэх нийт дам нөлөө эерэг байх хандлагатай хэдий ч салбар тус бүрийн хувьд энэ хамаарал ажилладаг эсэх, эерэг дам нөлөөний хэмжээ үр ашигтай байж чадах эсэх асуудал нь чухал юм.

Уул уурхай, эрдэс баялагийн харилцааг илүү үр ашигтай, хүртээмжтэй, эерэг нөлөөлөлтэй болгох үүднээс ашигт малтмалын эрх зүйн шинэчлэл, оролцогчдын тэгш эрхийг хангах, зах зээлийг хөгжүүлэн төлөвшүүлэх, олон нийтэд суурилсан хариуцлага, хяналтын тогтолцоог бий болгох, мэдээллийн удирдлагыг хэрэгжүүлэн улс орны нийгэм, эдийн засгийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг тогтвортой хангах явдал нэн чухал болжээ.⁵ Шилжилтийн үе шатанд байгаа олон орон газар өмчлөх хувь хүний эрхийг илүү хүчтэй хүлээн зөвшөөрөх, уул уурхайн зах зээлийг сайн ажиллуулахад шаардлагатай үндсэн хууль эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоог бий болгоход чиглэж байна⁶.

Уг судалгаагаар төрийн өмчит компанийн удирдлагын онол арга зүй, олон улсын нийтлэг зохицуулалт, нөхцөл байдлын авч үзсэний зэрэгцээ төрийн өмчлөл, засаглалын онол арга зүй, харьцуулах үзүүлэлт, төрийн өмчит компаниудад тулгардаг асуудлууд, баялгийн засаглалын индекс, компаниудын сонголтын талаар ОХУ, Индонез, Бразил, Энэтхэг, Чили зэрэг улсуудын туршлагыг авч болно. Эдгээр улс орнуудын баялагийн засаглал нь төрийн өмчит компаниараа дамжуулан хийгддэг тул манай оронд судлан үзэх, сайн туршлага болохуйц байлаа.

Харьцуулалт хийх шалгуур үзүүлэлтүүдийг сонгохдоо улс орнуудын төрийн өмчит компаниудад тулгамдаж байгаа асуудлууд, баялгийн засаглалын индексийн үнэлгээний үр дүнг багасгах нөлөө үзүүлсэн буюу өмнөхтэйгөө харьцуулахад буурсан болон 0 үнэлгээтэй байгаа үзүүлэлтүүд зэргийг харгалзаж үзсэн бөгөөд авч үзсэн үзүүлэлтүүддээ баялгийн засаглалын индексийн Value realization нэртэй дэд хэсгийн State owned enterprise гэсэн үзүүлэлтийн бүтцийн элементүүдэд дахин шүүлт хийж дараах үзүүлэлтүүдийг гаргаж авлаа.

⁵ <http://www.fao.org/legal/development-law/land/en/>

⁶ <http://www.fao.org/legal/development-law/land/en/>

Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт

Шалгуур болгож авах үзүүлэлтүүд	Шалгуур үзүүлэлтүүд (англи)
1) Хуулийн хэлбэр, алсын хараа, стратеги, үйл ажиллагааны чиглэл; 2) Эрх зүйн гол зохицуулалтууд; 3) Бүтэц зохион байгуулалт, хяналт, удирдлагын тогтолцоо; 4) Удирдлагын бие даасан байдал; 5) Нийгмийн хариуцлага, олон нийтийн үйлчилгээ; 6) Компаний ёс зүйн дүрэм;	1. Legal form, vision, strategy, main operations; 2. Core legal regulations; 3. Governance, Organizational chart and monitoring system; 4. Managerial Autonomy; 5. SOE report legislative review requirement; 6. SOE code of conduct;

Улс орнуудыг сонгохдоо хоёр үндсэн шалгуурыг харгалзаж үзсэн болно.

Төрийн өмчтэй, эдийн засагт гүйцэтгэх эрдэс баялгийн салбарын гүйцэтгэх үүрэг өндөртэй. Үүнд:

- Төрийн өмчийн оролцоотой, төрийн эзэмшлийн хувь нь ерөнхийдөө өндөр компани;
- Эрдсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг орны төрийн өмчит компани;

- Уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөртэй орны төрийн өмчит компани;
- Борлуулалтаараа улс орондоо, бүс нутагтаа тэргүүлэгч зэрэг үзүүлэлтүүдийг хамруулсан.

5.1.1. ОХУ –ын уул уурхайн салбар дахь туршлага

Газпром нь эрчим хүчний үйлдвэрлэлээр дэлхийд томоохонд тооцогддог компаниудын нэг бөгөөд хий, хийн конденсат, газрын тосны геологи хайгуул, олборлолт, тээвэрлэлт, хадгалалт, боловсруулалт, борлуулалт, мөн хийг моторын түлш болгон боловсруулах, түүнчлэн дулаан, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Газпром нь байгалийн хий олборлолтоор дэлхийд тэргүүлэгч компани бөгөөд дэлхийн хийн үйлдвэрлэлийн 12%, ОХУ-ын хийн үйлдвэрлэлийн 68%-ийг эзэлдэг. Одоогийн байдлаар Ямалын хойг, Хойд туйл, Зүүн Сибирь, Алс Дорнодын хийн нөөцтэй холбоотой томоохон төслүүд, гадаадад нүүрс устөрөгчийн хайгуул, олборлолтын олон төслийг идэвхтэй хэрэгжүүлж байна.

Тус компани Орос болон гадаадын хэрэглэгчдийн хийн найдвартай нийлүүлэгч бөгөөд 175.2 мянган км урт дэлхийн хамгийн том хий дамжуулах системийг эзэмшдэг. Олборлосон хийнийхээ талаас илүү хувийг дотоодын зах зээл дээр борлуулдаг бөгөөд дэлхийн 30 гаруй оронд байгалийн хий нийлүүлж байна.

Түүнчлэн Оросын шингэрүүлсэн хийн хамгийн том үйлдвэрлэгч, экспортлогчдын нэг юм. Одоо хэрэгжиж буй Сахалин-2 төслийн хүрээнд шингэрүүлсэн хийн худалдааг амжилттай хөгжүүлэхээс гадна хурдацтай хөгжиж буй дэлхийн шингэрүүлсэн хийн зах зээл дэх байр сууриа бэхжүүлэхийг зорин шинэ төслүүдийг хэрэгжүүлж байна. Газпром нь ОХУ-ын хамгийн том нефть олборлогч дөрвөн компанийн нэг байхаас гадна Оросын эрчим хүчний үйлдвэрлэлийн 16 орчим хувийг эзэлдэг. Мөн дулааны үйлдвэрлэлээрээ ОХУ-д нэгдүгээрт ордог.

Тус улс уул уурхайн чиглэлийн төрийн өмчит компаниар дамжуулан үйл ажиллагаагаа явуулахдаа дараах эрх зүйн зохицуулалтуудыг баримталж байна.³³⁶ Үүнд:

- ОХУ-ын Иргэний хууль, Хувьцаат компанийн тухай Холбооны хууль, ОХУ-ын хийн хангамжийн тухай Холбооны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.
- Газпром нээлттэй хувьцаат компанийн дүрэм (Устав публичного акционерного общества «Газпром»)

Компанийн эрх зүйн байдал болон хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг ОХУ-ын Иргэний хууль, Хувьцаат компанийн тухай холбооны хууль, ОХУ-ын хийн хангамжийн тухай холбооны хууль, мөн энэхүү дүрмээр тодорхойлсон байна.

- Газпром компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүрэм (Положение о совете директоров ПАО «Газпром»)

Энэхүү дүрэм нь компанийн дотоод удирдлагын тогтолцооны үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх, удирдах нэгжүүдийн хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангах зорилготой.

- Газпром компанийн корпорацын засаглалын тухай кодекс (Кодекс корпоративного управления ПАО Газпром)

Энэхүү кодекс нь компанийн зүгээс хувьцаа эзэмшигчдийн эрх, ашиг сонирхлыг үр дүнтэй хамгаалах, хувьцаа эзэмшигчидтэй шударга харьцах, шийдвэр гаргалтад ил тод байдлын зарчмыг мөрдлөг болгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, компанийн бусад албан тушаалтнууд, хувьцаа эзэмшигчдийн мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагыг хангах, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, бизнесийн ёс зүйн тогтолцоог хөгжүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

- Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурлын журам (Положение об Общем собрании акционеров)

- Удирдах зөвлөлийн журам (Положение о Правлении)

Энэхүү журмаар дотоод аудитын чиг үүргийг гүйцэтгэх нэгжийн зорилго, зорилт, статус, эрх мэдэл, хариуцлага болон дотоод аудитын үйл ажиллагааны цар хүрээ, агуулгыг тодорхойлсон.

- Хяналтын комиссын журам (Положение о Ревизионной комиссии)

Хяналтын комиссын бүтэц, үүрэг, эрх мэдэл; ажиллах болон компанийн удирдлагын байгууллагатай харилцах журам; комиссын гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө цуцлах журам болон холбогдох бусад асуудлыг зохицуулдаг.

- Ногдол ашгийн бодлого (Дивидендная политика)

Энэхүү бодлогоор ногдол ашгийн хэмжээг тогтоох зарчим болон журам, мөн ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах журам, ногдол ашгийн татвар болон холбогдох бусад харилцааг зохицуулсан.

- Холбогдох бусад зохицуулалтууд зэрэг болно.

Газпром нээлттэй хувьцаат компани нь олон улсын стандартад нийцсэн компанийн засаглалын тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд энэ нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон бусад сонирхогч талуудтай үр дүнтэй харилцаа тогтоох боломжийг олгодог. 2021 онд Эксперт РА үнэлгээний агентлаг нь Газпромд А++ буюу менежментийн чанарын хамгийн өндөр үнэлгээ өгсөн байна.

Газпромын компанийн засаглалын гол субъектүүд нь Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөл, Удирдах зөвлөлийн дарга, Хяналтын комисс зэрэг удирдлага, хяналтын нэгжүүд болон гадаад аудитор байна.

Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурал нь компанийн удирдах дээд байгууллага юм. Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралд энгийн хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид санал гаргах эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигч бүр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй байна. Компанийн саналын эрх бүхий хувьцааны талаас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болдог. Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн үүрэг нь компанийн капиталжуулалт, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөгжлийн стратеги болон компанийн хөрөнгийг

удирдах зарчмуудыг тодорхойлох, компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнд компанийн хяналтын системийг оновчтой болгоход оршино.

Энэхүү зөвлөл нь 11 гишүүнтэй байдаг бөгөөд үүнийг Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурлаас өөрөөр тогтоож болно.

Удирдах Зөвлөл ба Удирдах Зөвлөлийн дарга нь гүйцэтгэх удирдлага бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг өгөх, компанийн өсөлт, хөгжлийн боломжийг хангах зорилготой бөгөөд юуны түрүүнд компанийн зорилго, стратеги, бодлогыг хэрэгжүүлэх, мөн Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурлаас гаргасан шийдвэрийг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Хяналтын комисс нь санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, компанийн нөхцөл байдлын талаар бие даасан мэргэшсэн дүгнэлт гаргадаг. Комиссын гаргасан дүгнэлтийг компанийн жилийн тайланд тусган Хяналтын комиссын санал хэлбэрээр Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурлын үеэр компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ. Тус комисс нь удирдлагын, дотоод хяналтын систем болон эрсдэл зохицуулалтын үйл ажиллагааг шалган, үр дүнгийн талаарх тайланг жил бүрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө бусад баримт бичгийн хамт хувьцаа эзэмшигчдэд илгээдэг. Хяналтын комиссын гишүүд нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болохгүй, мөн удирдлагын бусад албан тушаалыг давхар хаших боломжгүй. Түүнчлэн үйл ажиллагаагаа компанийн албан тушаалтнуудын санал, зааварчилгаанаас хамааралгүйгээр бие даасан байдлаар явуулна.

5.1.2. Индонез улсын уул уурхайн салбар дахь туршлага

PT Bukit Asam Tbk (PTBA) компани нь 1919 онд байгуулагдсан бөгөөд 2002 онд Индонезийн хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцаат компани гэж бүртгүүлсэн. Компани нь нүүрсний олборлолт болон олборлолтоос бусад гэсэн хоёр чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Нүүрсний олборлолтын үйл ажиллагааны хүрээнд судалгаа, хайгуул, ашиглалт, боловсруулалт, цэвэршүүлэлт, тээвэрлэлт, худалдаа зэрэг үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн гадаад, дотоодын нүүрсний боомт болон дулааны цахилгаан станцыг удирдан зохион байгуулдаг. Нүүрс олборлох үйлдвэрлэлтэй холбоотой заавар зөвлөгөө өгөхөөс гадна инженерийн үйлчилгээ үзүүлдэг байна. Түүнчлэн тус компани нь шахмал түлш боловсруулах, олборлох үйлчилгээ үзүүлдэг. Энэтхэг, Тайвань, Хятад, Хонгконг, Өмнөд Солонгос, Тайланд, Малайз, Филиппин, Япон, Вьетнам Улсуудтай хамтран ажилладаг.

- Индонезийн Компанийн Засаглалын тухай код (*Indonesian GCG General Code, 2020*);
- Төрийн өмчит компанийн тухай, 2003 оны 19 дүгээр хууль;
- Засаглалын Бодлогын Үндэсний Хорооноос 2016 онд гаргасан Компанийн
- засаглалын ерөнхий удирдамж;
- Авлигын гэмт хэргийг арилгах тухай хууль, (*1999 on the Eradication of Corruption crimes*);

- Холбоодын хууль (*Article of Association*);
- Авилгыг бууруулах тухай 2002 оны 30 дугаар хууль;
- Төрийн албан хаагчийн тухай хууль;
- Компанийн ёс зүйн дүрэм (*Code of Conduct*);
- Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн яамны журам;
- Төрийн өмчийн аж ахуйн нэгжийн яамны тушаал.

РТВА компани нь компанийн засаглалын үндсэн зарчим⁷ болох ил тод байдал, тайлагнал, үүрэг хариуцлага, шударга ёс, бие даасан байдлыг эрхэмлэн дараах зорилтуудыг хангахаар төлөвлөжээ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцааг удирдан чиглүүлэх;
- Компанийн өсөлтийг дэмжих;
- Хүний нөөцийг удирдах;
- Эрсдлийг үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэх;
- Компанийн имижийг бүрдүүлж, сайжруулах;
- Компанийн удирдлагын хууль бус асуудлаас урьдчилан сэргийлэх;
- Ажлын байрны ёс зүйн хэрэгжилтийг хангах зэрэг зорилтууд орно.

Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралдаан (*Shareholders and General Meeting of Shareholders*) Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралдаан гэдэг нь хувьцаа эзэмшигчид болон хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргах дээд хэмжээний нэгдсэн хуралдаан юм.

⁷ <https://www.ptba.co.id/pdf-files/397-0100-2020-07-Keputusan-Bersama-Dekom-dan-Direksi-PTBA-Tentang-Corporate-Governance-Policy-PTBA.pdf>

Комиссын зөвлөл (*Board of Commissioners*) нь компанийн менежментэд хяналт тавьж, удирдан чиглүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөгөө өгнө. Нэг ба түүнээс дээш гишүүнтэй байж болно. Комиссын зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралдаанаар томилно.⁸ Комиссын зөвлөл нь хяналтын зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна дараах 2 хорооны чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Бизнесийн эрсдэл, нэр дэвшүүлэх, цалин урамшуулал, хүний нөөцийн хөгжлийн хороо;
- Аудитын хороо гэсэн хороодууд орно.

Төлөөлөн удирдах зөвлөл (*Board of directors*) нь компанийн менежерийн үүргийг гүйцэтгэдэг. Хоёр ба түүнээс дээш гишүүнтэй байж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хуралдаанаар томилно. Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Дотоод аудит;
- Компаний нарийн бичгийн дарга;
- Эрсдэлийн менежмент;
- Компанийн менежментийн систем, компанийн засаглал.

Комиссын зөвлөл нь хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, сайжруулах зорилгоор Аудитын хороо, (*Audit Committee*), Бизнесийн эрсдэл, нэр дэвшүүлэлт, цалин

урамшуулал, хүний нөөцийн хөгжлийн хороо (*Business Risk, Nomination, Remuneration and Human Resources Development Committee*) зэрэг хороодыг байгуулсан.

Хяналт удирдлагын тогтолцоо “Төрийн өмчийн компанийн тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу компаний засаглал, удирдлага, хяналтыг Засгийн газрын журмаар зохицуулдаг байна. Төрийн өмчийн компаниудад тавих хяналт шалгалтыг Төлөөлөн удирдах зөвлөл болон Коммиссын зөвлөл хариуцна.

5.1.3. Бразил улсын уул уурхайн салбар дахь туршлага

Петробрас компани нь газрын тос болон байгалийн хийн хайгуул, олборлолт явуулах, боловсруулалт хийх зэрэг үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг. Үндэсний хэмжээнд газрын тос боловсруулах 13 үйлдвэртэй. Мөн Парана хотод шаварлаг занар боловсруулах үйлдвэртэй.

Нефть боловсруулах /цэвэршүүлэх/ үйлдвэр нь дизель, шатахуун, онгоцны түлш, шингэрүүлсэн хий, тослох материал үйлдвэрлэдэг. Сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор боловсруулах үйлдвэрүүдийн шинэчлэлд хөрөнгө оруулалт хийсэн байна.

Бразилын зах зээлд дотоодын үйлдвэрлэлийн байгалийн хийгээс гадна Боливи Улсаас импортолсон хий, шингэрүүлсэн байгалийн хийг нийлүүлдэг бөгөөд Петробрас компани импортолсон хийг дахин боловсруулдаг.

Байгалийн хийг дулааны цахилгаан станцууд түлш болгон ашигладаг. Түүнчлэн бусад салбарт мочефин, аммиак зэрэг өөр төрлийн бүтээгдэхүүн болгон хөрвүүлэхээс гадна тээврийн салбарт түлш болгож, өрх гэрүүд, үйлдвэрүүд эрчим хүчний эх үүсвэр болгон ашигладаг байна. Байгалийн нөлөөллөөр дамжуулан эрчим хүчний хэрэгцээг хангаж чадах дулааны, салхин, бага оврын усан цахилгаан станцуудад хувьцаа эзэмших замаар цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд оролцдог гэж хэлж болно.

Хууль:

- 2013 оны 8-р сарын 1-ний өдрийн 12,846 тоот хууль, энэ хууль нь үндэсний болон гадаадын засгийн газрын эсрэг үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн иргэний болон захиргааны хариуцлагыг сахих дүрмийг тогтоож холбогдох заалтуудыг тусгасан.

- 2015 оны 3-р сарын 18-ны өдрийн 8420 тоот авилгын эсрэг тогтоол;
- Гадаадын авлигын тухай хууль 1977 (FCPA);
- 2016 оны 6-р сарын 30-нд батлагдсан төрийн өмчит компанийн тухай хууль;
- SOX 2002 оны 7-р сард батлагдсан Sarbanes Oxley Act буюу SOX(АНУ-ын хөрөнгийн зээлд хувьцаа гаргасан Бразилын компаниудад хамаатай).

Бодлого, журам:

- Холбогдох акт, баримтын ил тод байдал, үнэт цаасны бодлогын талаар баримтлах зарчим;
- Дагаж мөрдөх бодлого;
- Бизнесийн эрсдлийн менежментийн бодлого;
- Омбудсманы бодлого (эрхийг баталгаажуулах, ил тод байдлыг дэмжих, иргэншлийг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, засаглал, хяналтыг байнга сайжруулах);
- Хувьцаа эзэмшигчдийн нөхөн олговрын бодлого (ногдол ашгийн бодлого);
- Петробрас компанийн ерөнхий бүтэц болон Петробрас компанитай холбоотой компаниудын аудитын хороо, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх албаны ажилтнуудыг томилох бодлого;
- Харилцааны бодлого;
- Петробрас-тай холбоотой талуудын ажил гүйлгээг зохицуулах бодлого;
- Компанийн засаглалын бодлого;
- Монополийн эсрэг ёс зүйн дүрэм;
- Сайн туршлагын дүрэм.

Петробрас компанийн засаглалыг бэхжүүлэхэд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Зохицуулалтууд нь компанийн засаглалын үндсэн зарчим болох ёс зүй, шударга байдал, ил тод байдал, тайлагнал, бие даасан байдлыг хангаж, удирдан чиглүүлдэг. Петробрас компани засаглалын шинэ загварыг хэрэгжүүлж, үйл явцын нийцлийг хангаж, ёс зүйгүй байдлаас урьдчилан сэргийлэх, ёс зүйгүй байдлыг илрүүлэх, залруулах механизмыг боловсруулсан.

Компанийн засаглалын шинэ загвар⁹ нь компанийн зохион байгуулалтын бүтэц, шийдвэр гаргах үйл явцыг хянасны үр дүнд үйл ажиллагааг нэгтгэх, төвлөрүүлэх, удирдах албан тушаалтныг сонгох, шударга байдлын шалгуурыг батлах, шийдвэр гаргалтын түвшинд удирдлагын хариуцлагыг дээшлүүлэх, хувь хүн болон компанийн ёс зүй, шударга, ил тод байдлын жишгийг тогтоох зорилготой.

Удирдах зөвлөл Хувьцаа эзэмшигчдийн ерөнхий хурлаар хоёр жил хүртэл хугацаагаар сонгогддог бөгөөд хамгийн багадаа долоо, дээд тал нь арван нэгэн гишүүнээс бүрддэг, гурван удаа дараалан дахин сонгогдох боломжтой. Удирдах зөвлөлийн гишүүдээс дарга, гүйцэтгэх захирал, ажилчдын төлөөлөгч хараат бус байдаггүй. Бусад гишүүд нь бие даасан гэж үздэг.

Санхүүгийн зөвлөл Дахин сонгогдох боломжтой, нэг жилийн хугацаатай ажиллах таван гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн нэгийг цөөнхийн хувьцаа эзэмшигчид, нэгийг давуу эрхийн хувьцаа эзэмшигчид, гурвыг нь Холбооны засгийн газраас буюу Сангийн сайдын Төрийн сангийн төлөөлөгч томилдог. Төсвийн зөвлөл нь сангийн хөрөнгийн удирдлага хууль тогтоомж, сангийн өөрийн хөрөнгө оруулалтын бодлогод нийцэж байгаа эсэхийг үнэлэх ёстой.

Гүйцэтгэх зөвлөл Энэ нь ТУЗ-өөс сонгогдсон, хоёр жил хүртэлх хугацаатай, дээд тал нь гурван удаа дараалан дахин сонгогдохыг зөвшөөрсөн дарга, долоон гүйцэтгэх захирлаас бүрдэх бөгөөд шаардлагатай үед огцруулж болно.

Удирдах зөвлөлийн хороод Төлөөлөн удирдах зөвлөл нь 6 зургаан зөвлөх хороотой байх бөгөөд тодорхой асуудлаар дүн шинжилгээ хийх, зөвлөмж өгөх үүрэгтэй. Эдгээрт хөрөнгө оруулалтын хороо, аудитын хороо, бизнесийн нэгдлийн Аудитын хороо; Аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл мэндийн хороо, хүний нөөцийн хороо зэрэг хороодууд багтдаг. Эдгээр хороод нь компанийг удирдах үүргээ биелүүлэхэд нь ТУЗ-д туслах зорилготой.

Зөвлөх хороо Гүйцэтгэх зөвлөл нь энэ байгууллага эсвэл түүний гишүүдийн аль нэгтэй нь холбоотой бүрэн эрх бүхий хороодыг байгуулж болно. Хороо нь зөвлөлдөх шинж чанартай байж болох бөгөөд гүйцэтгэх зөвлөлд туслах зорилготой байдаг. Асуудлыг шинжлэх, хэлэлцэх, шийдвэр гаргах үйл явцад олон талын оролцоог хангахын тулд эдгээр хороо нь компанийн төрөл бүрийн салбарын менежерүүдээс бүрддэг.

Хороодын бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг гүйцэтгэх зөвлөлөөс баталж, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаарбатлуулдаг. Зөвлөлдөх хороод нь үйл ажиллагаандаа дэмжлэг болгох үүднээс комисс, ажлын хэсгүүд байгуулж болно. Петробрас компани бохирдол, усны нөөц, үйлчилгээний менежмент, хог хаягдлын менежмент, аюулгүй ажиллагаа, хүний эрх, ханган нийлүүлэлтийн сүлжээ гэсэн чиглэлүүдээр тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна.¹¹

⁹ <https://www.investidorpetrobras.com.br/en/esg-environment-social-and-governance/governance/>

¹⁰ <https://petrobras.com.br/en/about-us/profile/compliance-ethics-and-transparency>

¹¹ <https://www.ongcindia.com/wps/wcm/connect/en/about-ongc/organogram/>

5.1.4. Энэтхэг улсын уул уурхайн салбар дахь туршлага

Төрийн өмчит Oil and Natural Gas Corp нь 2040 он хүртэлх шинэ баримт бичигт дотоод болон гадаад дахь газрын тос, байгалийн хийн олборлолтыг хоёр дахин нэмэгдүүлэх, боловсруулах хүчин чадлаа сэргээгдэх эрчим хүч болгон төрөлжүүлэхийн зэрэгцээ гурав дахин нэмэгдүүлэх зорилт тавьжээ.

Үйл ажиллагааны чиглэл

- Газрын тос, хийн үйлдвэрлэл;
- Хайгуул, олборлолт;
- Боловсруулах үйлдвэрлэл;
- Хийн хоолой;
- Эрчим хүч;
- Логистик.

Хууль

- Корпорацын тухай хууль;
- Газрын тосны талбайн зохицуулалт, хөгжлийн тухай хууль 1948 (Газрын тосны талбайн тухай хууль);
- Уурхайн тухай хууль 1952 (Уурхайн тухай хууль), газрын тосны уурхайн журам 2017
- Газрын тос, байгалийн хийн дүрэм 1959;
- Газрын тос, байгалийн хий (гадаад оронд явуулж буй үйл ажиллагааны аюулгүй байдал) дүрмүүд 2008 (аюулгүй байдлын дүрэм).

Дүрэм, журам

- Бодлого;
- ONGC шүгэл үлээгчийн бодлого/ сонор сэрэмжтэй байдлын механизм-2018 он;
- Ёс зүйн дүрэм;
- Холбоотой талуудын ажил гүйлгээний талаар баримтлах бодлого;
- Охин компанийн талаар баримтлах бодлого;
- Инсайдерын арилжааны журмыг хориглох бодлого;
- Баримт бичгийг хадгалах талаарх бодлого;
- Үйл явдалд тодруулга хийх бодлого;
- Эрсдэлийн менежментийн бодлого;
- Ногдол ашиг хуваарилах бодлого;
- Залилангаас урьдчилан сэргийлэх бодлого.

1959 онд Парламентын шийдвэрийн дагуу ONGC нь бие даасан байгууллага болжээ. Гэхдээ компанид санхүүгийн болон зохион байгуулалтын бие даасан байдал дутагдаж байна. ONGC нь Засгийн газрын компани бөгөөд бүтэн цагаар ажиллах чиг үүргийн захирлуудыг томилох, цалин хөлс олгох нөхцөлийг Засгийн газар захиргааны асуудал хариуцсан яам, Газрын тос, байгалийн хийн яамаар дамжуулан тогтооно. Компанийг төлөөлөн удирдах зөвлөл удирдаж, стратеги, бодлого боловсруулж, гүйцэтгэлийг хянаж байдаг. Дарга, гүйцэтгэх захирал болон дотоодын асуудал, технологи, засвар үйлчилгээ, санхүү, гадаадын асуудал, хайгуул, хүний нөөцийн асуудал хариуцсан захирлууд компанийн өдөр тутмын бизнесийн асуудлыг удирдах зөвлөлийн хяналт дор удирдан зохион байгуулдаг. Түүнээс гадна Удирдах зөвлөлийн дэргэд Оролцогч талуудын харилцааны хороо¹² Компанийн нийгмийн хариуцлагын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо зэрэг хороодууд үйл ажиллагаа явуулдаг. ONGC компани тогтвортой хөгжлийн чиглэлээр Хүлэмжийн хийг хэмжих, бууруулах, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, усны тогтвортой менежмент, цаасгүй оффис төслийг хэрэгжүүлэх санал санаачлагыг гарган ажиллаж байна.

5.1.5. Чили улсын уул уурхайн салбар дахь туршлага

Коделко компани нь эрдэс баялгийн талаар судалгаа хийж, эрдэс баялгийг хөгжүүлж, ашиглаж, боловсруулж цэвэршүүлсэн зэс, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулдаг бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний хувийг дангаараа хангадаг. Коделко компани нь дэлхийд дээрээсээ хоёрт орох молибден үйлдвэрлэгч бөгөөд 2020 онд нийт 1.7 сая тонн зэс олборлосон. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд компани нь Чили Улсын хөгжлийн төлөө үйл ажиллагаагаа зориулдаг гэж хэлж болно. Татварын өмнөх ашиг, төрийн санд оруулах хувь нэмрээрээ дамжуулан Коделко компани Чили Улсын хөгжлийг дэмжих, Засгийн газарт санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлэхэд нь, ялангуяа өнөөдрийнх шиг цар тахал өвчин дэгдсэн зэрэг хүнд хэцүү үеүдэд шууд тусалдаг. Үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд төслийн чанар, үнэ цэнэ, уурхайн хөгжилд чиглэсэн стратегийн бизнес төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд 2022 онд бага зардалтайгаар ажилладаг салбарын шилдэг компаниудын 50%-д багтаж, татварын өмнөх ашгаа нэмэгдүүлэхийг зорьж байгаа. Стратегийн хэрэгжилтийг хангахад тогтвортой хөгжил, ил тод байдал, өндөр стандарт, хүний нөөцийн шинэчлэл, хөгжил зэрэг үзүүлэлтүүд чухал нөлөө үзүүлнэ гэж үздэг. Хэрэгжүүлэх төслүүд, өрсөлдөх чадвар дээрээ түшиглэж ирэх 50 жилийн

хугацаанд Чили Улсын хөгжлийн санхүүжилтэд томоохон хувь нэмэр оруулна гэж төлөвлөсөн.

Коделко нь 1976 онд байгуулагдсан бөгөөд уул уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Чили Улсын төрийн өмчит компани юм. Тус компани нь 1971 онд томоохон уурхайнуудын менежментийг төрийн мэдэлд шилжүүлэх үйл явцын үр дүнд улсын өмч болсон. Коделко компани уул уурхайн яамаар дамжуулан Засгийн газарт үйл ажиллагаагаа тайлагнадаг бөгөөд 1.350 тоот хуулийн тогтоолд өөрөөр зааснаас бусад тохиолдолд ердийн хууль тогтоомжоор зохицуулагддаг. 2009 оны 11 дугаар сарын 14-ний өдөр албан ёсны сонинд нийтлэгдсэн 20.392 тоот хууль нь 1.350 дугаар тогтоолын дагуу тогтоосон Коделкогийн органик дүрмийг өөрчлөх, ашиглагдахгүй хөрөнгийг устгах журмыг шинэчилсэн.

¹²https://www.codelco.com/prontus_codelco/site/artic/20200531/asocfile/20200531230507/codelco_at_a_glance_december_31__2020.pdf

- Чилийн 1350 тоот органик хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Авлигын эсрэг хууль тогтоомж;
- Өрсөлдөөний тухай хууль;
- Төрийн албаны ил тод байдал, төрийн удирдлагын талаархи мэдээлэл авах тухай
- Лоббиг зохицуулах хууль;
- Компанийн засаглалын хууль.

Бодлого, дүрэм

Бусад бодлого

- Амьдралын чанарын бодлого;
- Архи, мансууруулах бодис, тамхины талаар баримтлах бодлого;
- Нийлүүлэлтийн бодлого;
- Бизнесийн ёс зүйн бодлого;
- Маркетингийн бодлого;
- Коделкогийн ханган нийлүүлэгч, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчтэй харилцах харилцааны хүрээ;

Дүрэм

- Коделко компанийн 24-р стандарт (хүмүүс, хүрээлэн буй орчин, олон нийтийн байгууллагууд, бараа бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийн шинжилгээ);
- Уугуул иргэдийн өмнө хүлээсэн үүрэг;
- Олон нийтийн харилцааны гарын авлага;
- Экологийн талаар хүлээсэн амлалтууд;
- Байгаль орчин, мэргэжлээс шалтгаалах аюулын тухай дүрэм;
- Хөрөнгө оруулалтын төслүүдийн эрчим хүчний хэмнэлтийн гарын авлага;
- Эрчим хүчийг үр ашигтай ашиглах талаарх компанийн удирдамж;
- Коделко Chile Уул уурхайн үйл ажиллагааг хаах компанийн удирдамж;
- Аюулгүй байдлын хяналтын стандартууд.

Коделко компани нь есөн гишүүнээс бүрдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн удирдлага дор ажилладаг. Төлөөлөн удирдах зөвлөл нь дөрвөн жилийн хугацаатай сонгогдож ажилладаг. Удирдах зөвлөлийн гишүүдийг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилдог бөгөөд ажилд томилогдсон ТУЗ-ийн гишүүдийн бүрдлийг дараах байдлаар хангадаг.

Үүнд: Төрийн менежментийн зөвлөлөөс санал болгосон 4 гишүүн, Зэсийн салбарын ажилчдын холбоо, Зэс үйлдвэрлэгчдийн хяналтын үндэсний холбоо хамтран санал болгосон таван хүний жагсаалтыг үндэслэн Коделко компанийн 2 төлөөлөгч, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөс шууд томилдог 3 гишүүн, нийт 9 гишүүн төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлдэг. Удирдах зөвлөлийн гишүүд Корпорацад удирдах албан тушаал зэрэг хаших боломжгүй.

Удирдах зөвлөлийн хороо Удирдах зөвлөлд эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудлыг хариуцдаг таван хороо дэмжлэг үзүүлж ажилладаг. Удирдах зөвлөлийн хороодын бүтэц, үүрэг байх ёстой болохыг төрийн удирдлагын зөвлөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн Аудит, нөхөн олговор, ёс зүйн хороо шаардаж байдаг. Таван хороодын үүрэг, үйл ажиллагааг товч авч үзвэл дараах байдалтай байна.

Аудит, нөхөн төлбөр, ёс зүйн хороо Энэ нь Коделко компанийн засаглалын тухай хууль, ТУЗ-ийн хорооны үйл ажиллагааг зохицуулах корпорацын тухай хуульд заасан аудит, нөхөн төлбөртэй холбоотой үүргийг гүйцэтгэдэг.

Төсөл, хөрөнгө оруулалтын санхүүжилтын хороо Байгууллагын хөрөнгө оруулалтын санхүүжилтийн механизмд дүн шинжилгээ хийхээс гадна менежментийн загвар, урт хугацааны тогтвортой байдал зэрэг хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд авч үзвэл зохих асуудлуудыг хариуцдаг.

Удирдлагын хороо Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал бизнес, борлуулалтын бодлого, хүний нөөц, олон талын оролцоо зэрэг асуудлуудад хяналт тавьдаг.

Тогтвортой байдлын хороо Тогтвортой байдлын бодлого, ялангуяа тогтвортой байдлын зорилго, байгаль орчин, нийгэмтэй холбоотой асуудлын хүрээнд (Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Байгаль орчин, олон нийтийн байгууллагын менежмент) тогтвортой байдлын тухай хууль тогтоомж, дүрэм журмын нийцэл, тогтвортой байдлын тайлан, корпорацын нийгмийн бүлгүүдэд үзүүлэх нөлөөлөлд хяналт тавьдаг.

Шинжлэх ухаан, технологи, шинэчлэлийн хороо Энэ нь инновацийн менежментийн систем (IMS)-ийн үйл ажиллагаа, компанийн инновацийн соёлын хэрэгжилт, дэмжлэгт хяналт тавьж, инноваци, технологийн төслүүдийн багцыг тодорхойлдог.

Коделко компани нь:

- Корпорацын засаглал ба тогтвортой байдал;
- Ёс зүй;
- Эрсдэлийн удирдлага;
- Хүний эрх;
- Байгаль орчин, экологи, биологи;
- Олон нийтэд хандсан дэмжлэг /ялангуяа Ковид-19 цар тахлын үед/;
- Уурхай орчмын бүс нутгийн хөгжил, боловсрол;
- Нийгмийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа;
- Аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд;

Хүний нөөц, авьяас, бүтээмж, соёлын өөрчлөлт, хүйс, чадвар, соёл зэрэгтэй холбосон ажиллах хүчний төрөлжүүлэлт зэрэгт онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Тухайлбал,¹³ байгаль орчин, эдийн засаг, нийгэмд ээлтэй байх чиглэлээр хүлэмжийн хийн ялгаруулалтаа 70%-иар бууруулж, 100% цэвэр цахилгаан эрчим хүчээр хангах, хаягдлынхаа 65 хувийг дахин боловсруулах, нийгмийн үнэ цэнэ бүхий нутаг дэвсгэрийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх, ялангуяа дотоодын ханган нийлүүлэгчдийн бараа, үйлчилгээг 60%-иар өсгөж, орон нутагт ажиллах хүчийг нэмэгдүүлэх, нутаг дэвсгэрийн интеграцийн шинэ стратеги хэрэгжүүлэх зэрэг төлөвлөгөө боловсруулсан ажиллаж байна.

Коделко¹⁴ нь Сангийн яамны бодлого, үйл ажиллагаанаас хамааралтай гэж хэлж болно. Энэ утгаараа Коделко нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, ялангуяа ашгаараа дахин хөрөнгө оруулалт хийх эрх мэдлийг хэрэгжүүлэх тал дээр сул талтай байдаг. Эрдэмтэн судлаачид илүү бие даасан корпорацын засаглал шаардлагатай байгаа талаар дүгнэж, онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд Төлөөлөн Удирдах Зөвлөл санхүүжилт, ногдол ашгийн тодорхой дүрмийг өөрөө тодорхойлж, санхүүгийн менежментийнхээ асуудлыг хараат бусаар шийдэж байх нь зүйтэй гэж үздэг.

Компанийн зүгээс Чилийн төрийн санд төвлөрүүлэх ногдол ашгийн төлбөр өндөр байдаг бөгөөд төрийн сангийн хөрөнгө оруулалтын зарцуулалт харьцангуй их байх үед, энэ нь компанийн мөнгөн урсгалын хэмжээг багасгах нөлөөг бий болгодог.

Улсын төсөвт хөрөнгө оруулалтын зардал харьцангуй ихээр туссан үед, засгийн газрын зээлийн санхүүжилт нэмэгдэх бөгөөд үр дүнд нь Коделко компанийн мөнгөн урсгалын хэмжээ буурах нөхцөл бүрдэж байдаг гэж хэлж болно.

¹³ https://www.codelco.com/prontus_codelco/site/artic/20210520/asocfile/20210520085342/sustainability_report_2020_codelco.pdf

¹⁴ <https://www.cesco.cl/en/2020/10/30/codelcos-pending-tasks/>

5.2.Бүлгийн дүгнэлт

Олон улсын практикийн судалгаанд хамрагдсан улсууд нь ашигт малтмалын салбарын хариуцлагыг нэмэгдүүлэх, газар түүний доорх баялагийн тогтвортой, үр ашигтай байдлыг улам нэмэгдүүлэх замаар улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулахыг эрмэлзэж байна. Мөн судалгаанд хамрагдсан улс орнууд нь ашигт малтмалын салбар дахь төрийн өмчит компаниудын хууль эрх зүйн орчинг тогтвортой, ойлгомжтой, ил тод, сайн засаглалын зарчимд нийцүүлэн хуульчилсан нь уул уурхайн салбар дахь жишиг сайн туршлага болон харагдаж байгааг онцлох нь зүйтэй.

Магадгүй манай орны хувьд ч энэ асуудлыг судлаж, амьдралд нийцүүлэх нь зайлшгүй бөгөөд дэлхийн жишигт нийцсэн уул уурхай, эрдэс баялагийн эрх зүйн харилцааг хөгжүүлэх нь бодлого тодорхойлох түвшинд тулгарч буй шинэ хандлага, шинэ сорилт, ойлголт болж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудыг тодорхой шалгуурын хүрээнд судлан үзсэнийг энэхүү ажлын тайланд өмнө нь тусгасан ба нэгдсэн бодлого, эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалт, хариуцлага, хяналтын тогтолцоо тус бүрийг хуульчлан тогтоож дагаж мөрдөж байгаа нь иргэний эрх зүйт төртэй улс орнуудад зайлшгүй байх хууль эрх зүйн хэм хэмжээ болсныг илтгэж байна.

ЗУРГАА.ЗӨВЛӨМЖ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын ашигт малтмалын салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбаруудаас эрх зүйн зөв, тогтвортой орчинг бий болгох хуулийн төсөл боловсруулах замаар ашигт малтмалын баяжуулалтын үйл ажиллагаа, хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох, уурхай, үйлдвэрийн хаалтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох, орон нутгийн уялдаа холбоо, иргэд, олон нийтийн оролцоо, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хамарсан эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг бий болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1- д заасны дагуу өнөөдрийн тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийг цогцоор шийдвэрлэх боломжийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар хангаж байна гэж үзэв.

---oOo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай
- Ашигт малтмалын тухай хууль
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. “Эрдэс баялгийн статистик мэдээ: 2022/03”; -- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор (LL.D.) –
- О.Мөнхсайхан. “Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлал: Газрын хэвлийн баялаг ашиглахад баримтлах зарчмууд”, 2020;
- Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайлан”, 2022;
- Австрали-Монголын эрдэс баялгийн хөтөлбөр. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах журам, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, 2021;
- Ашигт малтмалын тухай хууль, 2006;
- Хууль тогтоомжийн тухай хууль, 2015;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”;
- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалын хавсралт “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”;
- П.Очирбат, “Монгол Улсын эрдэс баялгийн цогцолборын хөгжлийн стратеги ба экологи”, УБ, 1998
- Я.Гомбосүрэн, “Эрдсийн баялгийн олборлолт, боловсруулалтын технологи, экологи-эдийн засгийн үнэлгээний онол, арга зүй”, Улаанбаатар, 2004
- Я.Гомбосүрэн, Монголын ашигт малтмалын ордууд, Улаанбаатар, 1977
- Д.Галсандорж, Д.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхжаргал, Монгол улсын уул уурхайн бүтээгдэхүүний олон улсын худалдаа, өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, Олон улс судлал сэтгүүл, 2011 №2
- Харьцуулсан судалгаа /Судлаач-Ц.Болормаа, Г.Билгээ, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа/
ОХУ
- Компанийн тухай <https://www.gazprom.ru/about/>
- Газпром компанийн тухай <https://www.gazprom.ru/investors/documents/>
- компанийн хөрөнгө оруулалт <https://www.gazprom.ru/investors/corporategovernance/>
- Кодекс корпор »https://www.gazprom.ru/f/posts/60/091228/kodeks_korporativnogo_upravleniya17.pdf
- Газпром компанийн бүтэц <https://www.gazprom.ru/investors/corporate-governance/>
- Ногдол ашгийн тухай <https://www.gazprom.ru/investors/faq/>
- Индонез Улс**
- РТВА компанийн засаглалын бодлого <https://www.ptba.co.id/pdf-files/397-0100-2020-07-Keputusan-Bersama-Dekom-dan-Direksi-PTBA-Tentang-Corporate-Governance-Policy-PTBA.pdf>
- РТВА компанийн засаглал <https://www.ptba.co.id/en/good-corporate-governance/goodcorporate-governance>
- РТВА компанийн Аудит https://www.ptba.co.id/audit_keuangan/laporan-audit-keuangantahun-2020.pdf
- РТВА компанийн хувьцаа эзэмшигч <https://www.ptba.co.id/en/investor/shareholders>
- РТВА компанийн санхүү <https://www.ptba.co.id/en/esg/financial-performance>
- РТВА компанийн тайлан, 2021 <https://www.ptba.co.id/images/Struktur-Saham-31-Mei-2021.jpeg>
- Хязгаарлагдмал хувьцаат компани тухай хууль, 2007 <https://irmadevita.com/wpcontent/uploads/2008/04/company-law-uu-40-2007.pdf>
- Индонезийн ногдол ашигийн төлбөр <https://www.paulhypepage.co.id/dividend-payments-inindonesia/>
- РТВА компанийн Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурал <https://www.ptba.co.id/en/investor/general-meeting-of-shareholders>
- Хувьцаа эзэмшигчдийн эрх зүйн зохицуулалт, Хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн хурлын шийдвэр, 2021 <https://media.neliti.com/media/publications/333612-legal-protection-againstminority-shareh-c7b7463e.pdf>
- Компанийн засаглал, 2020 https://www.ssek.com/images/publication_file/2116/chamberscorporate-governance-2020.pdf
- Компанийн засаглал, тайлангийн хэсэг, 2020 https://www.btn.co.id/-/media/User-Defined/Document/Tata-Kelola/eng/6-Asian-Corporate-Governance-Scorecard/Bonus/2021_partbonus/BA11AR-P357361.pdf?la=id
- Индонезийн компанийн ерөнхий хуулийн 1 дэх хэсэг <https://www.hg.org/legalarticles/general-overview-of-indonesian-company-law-part-1-57486>
- https://www.ptba.co.id/audit_keuangan/laporan-audit-keuangan-tahun-2020.pdf
- https://www.ptba.co.id/uploads/ptba_anggaran_dasar/20210522023133-2021-05anggaran_dasar023127.pdf
- Бразил улс**
- <https://petrobras.com.br/en/our-activities/performance-areas/refining/>

- <https://www.investidorpetrobras.com.br/en/esg-environment-social-andgovernance/> governance/
 - <https://petrobras.com.br/en/about-us/profile/compliance-ethics-and-transparency>
 - <https://sustentabilidade.petrobras.com.br/en/src/assets/pdf/Sustainability-Report-2020-Petrobras.pdf>
 - <https://www.resourcedata.org/dataset/rqi-petrobras-organizational-chart/resource/74c806f8-9ae1-4740-ae03-b33d61edd908>
 - <https://apicatalog.mziq.com/filemanager/v2/d/25fdf098-34f5-4608-b7fa-17d60b2de47d/3cf92cf5-efeb-74ab-cdb8-b76ec88c768e?origin=2>
 - <https://38odelco3838.com.br/en/about-us/profile/compliance-ethics-and-transparency/>
 - <https://books.google.mn/books?id=ik1ZBwAAQBAJ&pg=PA277&lpg=PA277&dq=noncommercialresponsibility+of+38odelco3838&source=bl&ots=b7nG-OHFPW&sig=AcfU3U0Uyp-6dkxjrlqK2qerlV4qps6gbA&hl=mn&sa=X&ved=2ahUKEwi6hZ3xiqbzAhWLv5QKHYYKiDskQ6AF6BAgPEAM#v=onepage&q=non-commercial%20responsibility%20of%20petrobras&f=false>
- Энэтхэг улс**
- <https://economictimes.indiatimes.com/industry/energy/oil-gas/ongc-adopts-new-energystrategy-2040-targets-doubling-of-oil-gas-production/articleshow/70721759.cms?from=mdr>
 - <https://www.ongcindia.com/wps/wcm/connect/en/about-ongc/organogram/>
 - <https://www.ongcindia.com/wps/wcm/connect/en/investors/shareholding-pattern/>
 - https://www.ongcvidesh.com/wp-content/uploads/2019/05/Code-of-conduct_ONGC-Videsh-2016.pdf
 - <https://www.ongcindia.com/wps/wcm/connect/en/about-ongc/organogram/>
- Чили улс**
- https://www.codelco.com/prontus_codelco/site/artic/20200531/asocfile/20200531230507/codelco_at_a_glance_december_31__2020.pdf
 - https://www.codelco.com/flipbook/reporte_sustentabilidad/2011/sitio/en/values.html
 - https://www.codelco.com/prontus_codelco/site/artic/20210520/asocfile/20210520085342/sustainability_report_2020_codelco.pdf
 - https://www.codelco.com/prontus_codelco/site/artic/20210520/asocfile/20210520085342/sustainability_report_2020_codelco.pdf – <https://www.cesco.cl/en/2020/10/30/codelcos-pending-tasks/>